



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/248/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитор: Г.Мөнхбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.2 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

67120, Хөвсгөл аймаг, Мөрөн сум
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khovsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2022.02.23 № 01/119
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Я.ЭРХЭМБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	163,952,078.19	164,227,569.69
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	18,738,714.00	19,057,964.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	15,025,964.00	15,025,964.00
335	Бусад авлага	3,712,750.00	4,032,000.00
3351	Байгууллагаас авах авлага	3,712,750.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	4,032,000.00
34	УРЬДЧИЛГАА	-	7,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	7,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	145,213,364.19	137,969,605.69
354	Хангамжийн материал	138,229,364.19	128,212,605.69
35410	Бичиг хэргийн материал	450,100.00	509,600.00
35420	Аж ахуйн материал	137,669,264.19	127,703,005.69
35440	Түлш, шатах тослох материал	110,000.00	-
35600	Мал амьтад	6,984,000.00	9,757,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	468,584,553.04	783,965,486.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	468,584,553.04	783,965,486.80
392	Биет хөрөнгө	248,454,553.04	457,900,486.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	36,559,370.00	195,780,273.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	(11,318,183.76)	(27,835,758.46)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	116,124,746.50	236,368,939.98
39204	Хуримтлагдсан элэгдэл	(70,662,746.50)	(154,907,093.10)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	77,745,034.14	124,023,551.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,792,288.16)	(61,518,492.55)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,060,922.88	25,060,922.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,156,610.88)	(15,783,520.73)
39209	Зам, гүүрийн байгууламж	151,023,808.40	151,023,808.40
39210	Хуримтлагдсан элэгдэл	(10,129,499.58)	(14,312,144.34)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,000,000.00	4,608,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,000,000.00)	(4,608,400.00)
393	Биет бус хөрөнгө	220,130,000.00	326,064,999.96
39301	Программ хангамж	7,100,000.00	7,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,130,000.00)	(3,695,000.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	215,160,000.00	322,660,000.00
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	632,536,631.23	948,193,056.49
4	НИИТ ӨР ТӨЛБӨР	15,264,464.00	15,025,964.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,264,464.00	15,025,964.00
413	Өглөг	15,264,464.00	15,025,964.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	238,500.00	-
4136	Бусад өглөг	15,025,964.00	15,025,964.00
41361	Байгууллагад төлөх өглөг	15,025,964.00	15,025,964.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	617,272,167.23	933,167,092.49
51	Засгийн газрын хувь оролцоо	617,272,167.23	933,167,092.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	856,306,089.24	963,806,089.24
51101	Өмч: - төрийн	856,306,089.24	963,806,089.24
512	Хуримтлагдсан үр дүн	(410,266,264.66)	(223,192,243.52)
51210	Өмнөх үеийн үр дүн	(383,823,665.41)	(431,587,168.78)
51220	Тайлант үеийн үр дүн	(26,442,599.25)	208,394,925.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	171,232,342.65	192,553,246.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	632,536,631.23	948,193,056.49

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	505,516,839.65	737,862,198.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,841,239.65	289,807,478.53
120	Нийтлэг татварын бус орлого	18,841,239.65	289,807,478.53
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,841,239.65	289,807,478.53
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,032,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,841,239.65	285,775,478.53
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	486,675,600.00	448,054,719.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	484,383,800.00	416,105,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	484,383,800.00	416,105,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,291,800.00	31,949,319.48
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,871,800.00	30,665,919.48
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	420,000.00	1,283,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	531,698,318.52	529,467,272.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	531,698,318.52	509,467,272.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	500,144,590.48	457,986,416.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	253,245,610.20	250,189,985.10
210101	Үндсэн цалин	194,297,000.00	195,710,402.10
210102	Нэмэгдэл	51,450,710.20	46,981,683.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,497,900.00	7,497,900.00
2102	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	33,085,177.91	33,045,826.69
210201	Тэтгэврийн даатгал	22,955,277.91	22,971,090.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,532,500.00	2,556,484.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,026,000.00	2,004,867.00
210204	Ажилгүйдлийн даатгал	506,500.00	501,218.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,064,900.00	5,012,167.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,885,634.85	13,240,860.52
210301	Гэрэл, цахилгаан	3,426,876.85	2,827,676.92
210302	Түлш, халаалт	10,419,782.00	10,413,183.60
210303	Цэвэр, бохир ус	38,976.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	14,373,811.83	11,520,707.50
210401	Бичиг хэрэг	1,427,100.00	1,257,190.00
210402	Тээвэр, шатахуун	8,755,607.26	6,335,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,103,665.00	1,546,367.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	44,200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,109,434.00	2,269,650.00
210408	Бараа материал акталсны зардал	933,805.57	112,000.00
2105	Нормативд зардал	4,518,100.00	126,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,518,100.00	126,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,399,899.00	2,521,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	215,500.00	546,500.00
210604	Урсгал засвар	4,184,399.00	1,974,700.00
2107	Томилолт, зочны зардал	4,246,700.00	7,215,000.00
210702	Дотоод албан томилолт	4,246,700.00	7,215,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	125,960,334.65	46,567,659.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	123,034,324.65	40,224,875.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	983,300.00	947,680.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,230.00	450,624.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	3,600,000.00

210807	Газрын төлбөр	645,480.00	645,480.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,429,322.04	93,558,877.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,725,192.80	45,698,511.33
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,704,129.24	47,860,366.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,553,728.04	51,480,856.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,687,576.00	46,106,976.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	916,600.00	5,105,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,488,436.00	39,090,066.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,282,540.00	1,911,910.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,866,152.04	5,373,880.59
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,866,152.04	5,373,880.59
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	20,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	20,000,000.00
221001	Их засвар	-	20,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(26,181,478.87)	208,394,925.26
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	261,120.38	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	261,120.38	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(261,120.38)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(26,442,599.25)	208,394,925.26

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	504,386,964.00	466,793,433.48
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	504,386,964.00	466,793,433.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	484,383,800.00	416,105,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	484,383,800.00	416,105,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,003,164.00	50,688,033.48
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,871,800.00	30,665,919.48
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,131,364.00	20,022,114.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	501,915,964.00	466,793,433.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	501,915,964.00	466,793,433.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,252,871.96	400,966,612.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	253,245,610.20	250,186,282.00
210101	Үндсэн цалин	194,297,000.00	195,706,699.00
210102	Нэмэгдэл	51,450,710.20	46,981,683.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,497,900.00	7,497,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,085,177.91	33,049,529.79
210201	Тэтгэврийн даатгал	22,955,277.91	22,973,609.35
210202	Тэтгэмжийн даатгал	2,532,500.00	2,556,780.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,026,000.00	2,005,104.13
210204	Ажилгүйдлийн даатгал	506,500.00	501,275.98
210205	Эрүүл мэндийн даатгал	5,064,900.00	5,012,760.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,885,634.85	13,240,860.52
210301	Гэрэл, цахилгаан	3,426,876.85	2,827,676.92
210302	Түлш, халаалт	10,419,782.00	10,413,183.60
210303	Цэвэр, бохир ус	38,976.00	-
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	15,242,690.00	9,961,837.50
210401	Бичиг хэрэг	1,657,900.00	1,316,690.00
210402	Тээвэр, шатахуун	8,154,800.00	6,130,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,103,665.00	1,546,367.50

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	44,200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,282,125.00	968,280.00
2105	Нормативд зардал	4,995,100.00	133,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,995,100.00	133,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,475,699.00	3,311,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	293,500.00	1,336,500.00
210604	Урсгал засвар	4,182,199.00	1,974,700.00
2107	Томилолт, зочны зардал	4,008,200.00	7,453,500.00
210702	Дотоод албан томилолт	4,008,200.00	7,453,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	125,692,960.00	53,762,659.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	122,766,950.00	40,219,875.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	983,300.00	947,680.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,230.00	450,624.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	645,480.00	645,480.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,621,800.00	29,867,244.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,621,800.00	29,867,244.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,663,092.04	65,826,820.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,770,976.00	45,426,976.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	4,467,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,488,436.00	39,090,066.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,282,540.00	1,869,910.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,892,116.04	1,661,130.59
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,892,116.04	1,661,130.59
213304	Хөрөнгийн		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	18,738,714.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		18,738,714.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,471,000.00</u>	(0.00)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,471,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,471,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	2,471,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,471,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(2,471,000.00)</u>	(0.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	(0.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	(0.00)	(0.00)
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	(0.00)	(0.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	856,306,089.24	171,232,342.65	-383,823,665.41	643,714,766.48
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	856,306,089.24	171,232,342.65	-383,823,665.41	643,714,766.48
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-26,442,599.25	-26,442,599.25
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	856,306,089.24	171,232,342.65	-410,266,264.66	617,272,167.23
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	856,306,089.24	171,232,342.65	-410,266,264.66	617,272,167.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-21,320,904.12	-21,320,904.12
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	856,306,089.24	171,232,342.65	-431,587,168.78	595,951,263.11
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	107,500,000.00		0.00	107,500,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	21,320,904.12	0.00	21,320,904.12
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	208,394,925.26	208,394,925.26
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	963,806,089.24	192,553,246.77	-223,192,243.52	933,167,092.49

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	416,105,400.00	414,444,269.81	1,661,130.19	99.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	416,105,400.00	414,444,269.81	1,661,130.19	99.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	370,676,200.00	369,017,293.81	1,658,906.19	99.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	250,195,800.00	250,186,282.00	9,518.00	100.0
210101	Үндсэн цалин	195,715,400.00	195,706,699.00	8,701.00	100.0
210102	Нэмэгдэл	46,982,500.00	46,981,683.00	817.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,497,900.00	7,497,900.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,379,700.00	33,049,529.79	1,330,170.21	96.1
210201	Тэтгэврийн даатгал	24,193,100.00	22,973,609.35	1,219,490.65	95.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,546,700.00	2,556,780.11	(10,080.11)	100.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,037,300.00	2,005,104.13	32,195.87	98.4
210204	Ажилгүйдлийн даатгал	509,300.00	501,275.98	8,024.02	98.4
210205	Эрүүл мэндийн даатгал	5,093,300.00	5,012,760.22	80,539.78	98.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,358,500.00	13,240,860.52	117,639.48	99.1
210301	Гэрэл, цахилгаан	2,940,400.00	2,827,676.92	112,723.08	96.2
210302	Түлш, халаалт	10,418,100.00	10,413,183.60	4,916.40	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	9,232,600.00	9,229,037.50	3,562.50	100.0
210401	Бичиг хэрэг	1,176,800.00	1,176,690.00	110.00	100.0

**Хөвсгөл аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210402	Тээвэр, шатахуун	5,537,700.00	5,537,700.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,546,800.00	1,546,367.50	432.50	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	971,300.00	968,280.00	3,020.00	99.7
2105	Нормативд зардал	133,600.00	133,500.00	100.00	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	133,600.00	133,500.00	100.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,314,800.00	3,311,200.00	3,600.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,339,100.00	1,336,500.00	2,600.00	99.8
210604	Урсгал засвар	1,975,700.00	1,974,700.00	1,000.00	99.9
2107	Томилолт, зочны зардал	7,509,800.00	7,453,500.00	56,300.00	99.3
210702	Дотоод албан томилолт	7,509,800.00	7,453,500.00	56,300.00	99.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,296,200.00	49,158,784.00	137,416.00	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,616,000.00	35,616,000.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	985,300.00	947,680.00	37,620.00	96.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	451,400.00	450,624.00	776.00	99.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	198,000.00	99,000.00	99,000.00	50.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	10,800,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	645,500.00	645,480.00	20.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,255,200.00	3,254,600.00	600.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,255,200.00	3,254,600.00	600.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,429,200.00	45,426,976.00	2,224.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,429,200.00	45,426,976.00	2,224.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,469,100.00	4,467,000.00	2,100.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,090,100.00	39,090,066.00	34.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,870,000.00	1,869,910.00	90.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	416,105,400.00	414,444,269.81	1,661,130.19	99.6
1320	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	416,105,400.00	414,444,269.81	1,661,130.19	99.6
122005	Улсын төсвөөс	416,105,400.00	414,444,269.81	1,661,130.19	99.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.0	00.0	00.0	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.0	00.0	00.0	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	22	22	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	8	8	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

		/төгрөг/
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,688,033.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,688,033.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,688,033.48
2104	Хангамж, бараа материалын зардал	732,800.00
210401	Бичиг хэрэг	140,000.00
210402	Тээвэр, шатахуун	592,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,603,875.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,603,875.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,612,644.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,612,644.08
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,738,714.40
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	18,738,714.40
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	50,688,033.48
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,688,033.48
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,665,919.48
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,022,114.00
131106	Төсвийн урамшуулал	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган, дотоод хяналтын журам боловсруулж, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын Төгс суурь стандарт аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Оюунгэрэл, аудитор Г.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 1 дүгээр сарын 21-ны өдрийн 24 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Хүнс, хөдөө аж ахуйн салбарт мөрдөгдөж буй төр, засгийн бодлого, шийдвэр, эрх зүйн хэм хэмжээг сурталчлан таниулах, хэрэгжилтийг ханган ажиллуулахын зэрэгцээ эдийн засгийн тогтвортой хөгжил, тэдгээрийн үр ашгийг дээшлүүлж, иргэдийг эрүүл, чанартай хүнсээр хүртээмжтэй хангахад чиглэгдэнэ" гэж тодорхойлжээ.

Хүнс хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын дотоод бүтэц, зохион байгуулалт, ажлын уялдааг боловсронгуй болгох, иргэн, төр, төрийн бус, олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллаж төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.
- Хүнсний болон хоол үйлдвэрлэлийн салбарт бүс, орон нутгийн онцлог, түүхий эдийн нөөцөд түшиглэсэн байгальд ээлтэй дэвшилтэт технологийг нэвтрүүлэн хүн амыг эрүүл хүнсээр хангах, "Нутгийн брэнд бүтээгдэхүүн"-үүдийг бий болгож бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэн импортыг дэмжин ажиллах.
- Газар тариалангийн үйлдвэрлэлд өндөр хүчин чадалтай орчин үеийн дэвшилтэт техникүүдийг ашиглан үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг дээшлүүлж 1 га-аас авах ургацыг нэмэгдүүлэх, хүн амынхаа хэрэглээг үр тариа, төмс хүнсний ногоогоор бүрэн хангах.
- Мал үржлийн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэн ажил үйлчилгээний хүрээг өргөтгөх, цэвэр, эрлийз болон нутгийн шилмэл үүлдэр, омгийн малын тоо толгойг нэмэгдүүлэн эрчимжсэн аж ахуйг дэмжиж нэг малаас авах ашиг шимийг дээшлүүлэх, мал аж ахуйн материаллаг бааз, бэлчээр, бэлчээрийн усан хангамж, тэжээлийн хэрэгцээг нэмэгдүүлснээр хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах.
- Салбарын хэмжээнд олон улсын болон засгийн газар, бусад эх үүсвэрүүдээр санхүүжигдэн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалт, эх үүсвэрүүдийг үр ашигтай зарцуулах, түүнд тавигдах хяналтыг сайжруулан үр дүнг дээшлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 2021 оны 43-р тогтоол, "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай" Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага дотоод хяналтын журам, заавар боловсруулж, баталгаажуулаагүй байна.

Дотоод хяналтын комисс нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган, улиралд нэг удаа хяналт хийж, тайлан эрхлэгчийн зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна. Байгууллагын үйл ажиллагааны төсөв санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр 6, хүний нөөц хүрээнд 2, салбарын чиглэлээр хийгдэж буй төсөвт ажлуудыг үр дүн гүйцэтгэлийн хүрээнд 4 чиглэлд хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 5.3 сая төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 531.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 315.6 сая төгрөгөөр буюу 49.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	0.3	0.3
Урьдчилж гарсан зардал	-	7.2	7.2
Бараа материал	145.2	138.0	-7.2
Биет хөрөнгө	248.4	457.9	209.4
Биет бус хөрөнгө	220.1	326.1	105.9
Нийт хөрөнгө	632.5	948.2	315.7
Өглөг	0.2	-	-0.2
Өмч-төрийн	856.3	963.8	107.5
Хуримтлагдсан үр дүн	-410.3	-223.2	187.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	171.2	192.5	21.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	632.5	948.2	315.7

Авлага 0.3 сая төгрөгөөр өссөн нь хувь хүмүүсээс авах авлага 0.3 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Урьдчилж гарсан зардал 7.2 сая төгрөгөөр өссөн нь ХХААХҮЯ-ны дата ланд технологи буюу "opengov.mn" цахим программын 2022 оны төлбөрийг урьдчилж төлснөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 7.2 сая төгрөгөөр буурсан байна. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүссэн асуудал байхгүй байна.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 209.4 сая төгрөгөөр өссөн нь Ногоон алт төслийн хүрээнд "Монголын бэлчээр ашиглалтын холбоо"-оос үнэ төлбөргүй орлого 2.5 сая, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны №А-1/1626 дугаар албан бичгээр НҮБ-ийн Хөдөө аж ахуйн байгууллагаас балансаас баланст 120.2 сая, аймаг дундын отрын бүсээс шилжүүлсэн 3.1 сая, ХХААХҮЯ-ны сайдын №145 тоот тушаалаар Хөдөө аж ахуйг дэмжих сангаас шилжүүлсэн 40.6 сая, Засгийн газрын 2021 оны 269-р тогтоолоор Малын Удмын Сангийн

Үндэсний төвөөс балансаас баланст шилжүүлсэн 24.9 сая, ХХААХҮЯ-ны 2021 оны худалдан авах төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн их засвар 137.9 сая, нийт 329.3 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Биет бус хөрөнгийн дүн өнгөрсөн оноос 105.9 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2021 оны 269-р тогтоолоор Малын Удмын Сангийн Үндэсний төвөөс балансаас баланст 107.5 сая төгрөгөөр өсөж, тайлант оны элэгдлийн зардлын 1.5 сая төгрөгийн өсөлтөөс шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 223.2 сая төгрөг болж 187.0 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 21.3 сая, тайлант оны үр дүнгийн 208.4 сая төгрөгөөс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 2.2 сая төгрөгөөр буюу 0.4 хувиар буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 371.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 371.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант хугацаанд төсөвт тодотгол хийж, төсвийг 45.1 сая төгрөгөөр өсгөж, 416.1 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 416.1 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 416.1 сая төгрөгийг улсын төвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвийн санхүүжилтийн 416.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 414.4 сая төгрөгийг зарцуулж, 1.7 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 414.4 сая төгрөг буюу 99.6 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн өмнөх оны авлага барагдсан 18.7 сая, аймгийн Засаг даргын 2021 оны А/93 дугаар захирамжаар шатахууны зардал 0.6 сая, 2021 оны А/125 дугаар захирамжаар хяналтын постуудад ажиллах албан хаагчдын хоолны материалын зардалд 0.2 сая, 2021 оны А/475 дугаар захирамжаар “Шинэ хөдөө-Хөвсгөл” төслийн хүрээнд хэрэгжиж байгаа Цөм сүргийн аж ахуйн үйл ажиллагаанд 4.5 сая, 2021 оны А/504 дугаар захирамжаар авто машины гаалийн татварт 24.2 сая, 2021 оны А/624 дугаар захирамжаар 1.0 сая, 2021 оны А/38 дугаар захирамжаар 1.0 сая, цахим тендерийн хураамжийн орлого 0.2 сая, нийт 50.7 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс: Хангамж, бараа материалын зардал 0.7 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 4.6 сая, бараа үйлчилгээний бусад зардал 26.6 сая, нийт 31.9 сая төгрөгийг зарцуулж, 18.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого төвлөрүүлээгүй ба орсон орлогыг зориулалтыг дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус байгууллага 2021 оны батлагдсан төсөвт зардлын 0.9 хувиар буюу 1.3 сая төгрөгийн хэмнэлт гаргасан.
- Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээний батлагдсан төсөвт зардлыг 0.1 сая төгрөгөөр хэмнэсэн нь тогтоолын хэрэгжилт хангагдаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл гараагүй болно,

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 619.5 сая төгрөгийн 125 мэдээллээс 585.4 сая төгрөгийн 118 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, авлага, өглөгийн 34.0 сая төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна" гэж заасантай нийцэхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлээгүй нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй.
- Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн алдаа, зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна,

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар 2019 онд үүссэн малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх зардлын үлдэгдэл 6.3 сая, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх зардлын үлдэгдэл 8.7 сая, нийт 15.0 сая төгрөгийн шүүхийн маргаантай өглөг, уг өглөгтэй холбоотой нэмэлт санхүүжилтийн 15.0 сая төгрөгийн авлагын шийдвэрлэсэн байдлыг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1.5 сая төгрөгийн алдаа илэрснээс, 1.5 сая төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч ажиллалаа

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалын дэлгэрэнгүй тайланд 1.5 сая төгрөгийн орлогыг дутуу тайлагнасан.
- Зэрэгцүүлсэн мэдээлэл өмнөх тайлант хугацааны дүн нь өмнөх оны санхүүгийн тайлагналын аудитын дүнтэй дүйцэж буй байдлыг хянахад санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны гүйцэтгэлийг зөрүүтэй мэдүүлж тайлагнасныг санхүүгийн тайланд залруулав.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1.1 Илрүүлэлт:

Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *"Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй холбоотой мэдээллийг тухайн аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээдийн /гүйцэтгэх удирдлага буюу түүнээс эрх олгосон бусад этгээд/ бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно"* гэж заасантай нийцэхгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж:

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж, хэрэгжүүлж ажиллах.

1.2.1 Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 619.5 сая төгрөгийн 119 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна" гэж заасантай нийцэхгүй байна.

1.2.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна" гэж заасан хуулийн хугацааг хэрэгжүүлж

ажиллах, шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хүнс хөдөө аж ахуйн газар	3	1.5	1	1.5	-	-	-	-	2	-